




ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

# ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Албан хэрэгцээнд зориулав.



УЛААНБААТАР ХОТ, 2020.01.31



# АГУУЛГА



- I. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТӨЛӨВЛӨЛТ
- II. ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДУДАЖ НАСЛАЛТ
- III. БАРИМТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН
- IV. АСУУЛГЫН БОЛОН ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН
- V. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

# ҮНДЭСЛЭЛ

Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт “ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГЭМ, СОЁЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ ОРОЛЦОО, ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛД СУУРЬ СУДАЛГАА ХИЙХ” үйл ажиллагааг тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2019 оны 60 дугаар захирамжийн хүрээнд “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү өндөр байгаагийн шалтгаан нөхцөл”-ийг тодруулах судалгааг явууллаа.

Дундаж наслалтын зөрүүтэй байдалд нөлөөлж буй НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ, ЗАН ҮЙЛИЙН суурь шалтгааныг илрүүлэхийн тулд ТООН БОЛОН ЧАНАРЫН АРГААР мэдээлэл цуглуулж судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хүний амьдрах хугацааг тодорхойлох гол хэмжүүр нь ДУНДАЖ НАСЛАЛТ юм.

2017 оны 129  
дүгээр тогтоол

2019



5  
сар




6  
сар

# ЗОРИЛГО

2019

6 сар

Судалгааны гол зорилго нь Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, үүний дотор эрэгтэйчүүдийн эрүүл мэндээ хамгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага дадлыг тодорхойлж дүн шинжилгээ хийх юм. Уг судалгааны үр дүнд эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх замаар дундаж наслалтын зөрүүг багасгах, улмаар нийт дундаж наслалтыг нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулах юм.



**ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН  
ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮ ТҮҮНД  
НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС**



**ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛАХ,  
ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ,  
ХАНДЛАГА, ДАДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА**



2019

6 сар

7 сар

8 сар

9 сар

10 сар

11 сар

12 сар

2020

5 сар

1 сар

ТӨЛӨВЛӨЛТ

# II. ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2018



ЭРЭГТЭЙ

ЭМЭГТЭЙ


НИЙТ ХҮН АМ  
3 238, 5 МЯНГАН

1945 оны дайны дараах он жилүүдэд төрсөн хүн (1946-1956)

Монгол Улсын их үйлдвэржилтийн үед төрсөн хүн (1966-1976)


1986-1996 онд төрсөн хүн

1996-2006 онд төрсөн хүн



1 646,6  
мянга

1 591,9  
мянга




■ Эрэгтэй  
■ Эмэгтэй




ЖЕНДЭРИЙН  
СТАТИСТИК

# НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

(100 эмэгтэй хүн тутамд Х эрэгтэй)



## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР



2018




ЖЕНДЭРИЙН  
СТАТИСТИК

# ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮ

9.7  
ЖИЛ


2018

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1992 онд 4.2 байсан бол 2.3 дахин өсч 2018 онд 9.7 болсон нь бодлогын түвшинд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай, ноцтой хэмжээнд хүрсэн байна.




ЖЕНДЭРИЙН  
СТАТИСТИК

## ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, АЙМГААР



## ЭМЭГТЭЙ, ЭРЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮ ЖИЛЭЭР, АЙМГААР, 2018 ОН

2018






## ДУНДАЖ НАСЛАЛТ ХАМГИЙН ИХ БОЛОН БАГА УЛС ОРНУУД, 2016 ОН




Эх сурвалж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

2016



## ДУНДАЖ НАСЛАЛТЫН ХҮЙСИЙН ЗӨРҮҮ ӨНДӨР УЛСУУД 2016 ОН




Монгол улс зөрүү хамгийн их орнуудаас **12-т**, Зүүн Ази, Номхон Далайн бүсийн орнуудаас **2-т** жагсаж байна.

Дундаж наслалтын зөрүү их байгаа 15 орны 8 нь хуучин Зөвлөлт Холбоот улсын бүрэлдэхүүнд байсан социалист улс орнууд байна.

# ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН МЭДЭЭЛЭЛ


- 10 нас баралт тутмын 6 эрэгтэй, 4 эмэгтэй хүн байна.



**НАС БАРСАН ХҮМҮҮСИЙГ ХҮЙСЭЭР НЬ АВЧ ҮЗЭХЭД**

## НАСНЫ БҮЛГИЙН ХУВЬД

Хөдөлмөр эрхлэх насандаа нас барсан




- Эрэгтэйчүүдийн нас баралт 15 наснаас эхлэн эмэгтэйчүүдээс их болж, 45 наснаас огцом нэмэгджээ.
- Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйгээс **3.3** дахин илүү болжээ.

## НИЙТ НАС БАРАЛТ

# 18023


# 2018






Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү ихэсч, эрчүүд богино насалж байгаагийн хамгийн том шалтгаан нь **ХАЛДВАРТ БУС ӨВЧИН** байна.

### НАС БАРАЛТАД ХҮРГЭСЭН ӨВЧИН



Халдварт бус өвчлөл болох **ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ** өвчин, **ХАВДАР** гэсэн 2 өвчлөл 1995 оноос хойш нас баралтын зонхилох шалтгаан болж байна.




**ЗҮРХ, СУДАСНЫ ТОГТОЛЦОО** 58% 42%  
**ХАВДАР** 55% 45%


## ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

### ХҮЙСИЙН ХУВЬД

■ эрэгтэй ■ эмэгтэй



### ШАЛТГААН



Нас баралтын шалтгааны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс өвчлөлөөр **1.5** дахин, бусад ослоор **3.8** дахин, зам тээврийн осолд өртсөн тохиолдол **2.8** дахин, амиа хорлолтоор **5.8** дахин, бусдад хорлогдсон тохиолдол **4.1** дахин их. Үйлдвэрлэлийн ослоор нас барсан тохиолдол **бүгд эрэгтэй** байна.

Нас баралтад нөлөөлж буй хамгийн том хүчин зүйлс нь эрүүл мэндийн асуудал болох өвчлөл **83.1%** байна. Бусад осол, гэмтэл, амиа хорлолтын шалтгаанууд **16.9%** эзэлж байна.

## БУСАД ОСОЛ

Спиртэнд  
санамсаргүй  
хордох -46%  
/хамгийн их/



82%



18%

Байгалийн хүчинд  
өртөх

80%

20%

Усанд живэх

77%

23%

Бусад ослын шалтгаанаар нас барсан хүмүүсийн дийлэнх нь эрэгтэйчүүд (80%) байна.

Хэдийгээр эрэгтэй хүмүүсийн дундаж наслалт бага байгаа нь өвчлөлөөс хамгийн их шалтгаалж буй боловч **НАСНЫ БҮЛГИЙН ХУВЬД ЯЛГААТАЙ** байна:

Дундаж наслалтын хүйсийн зөрүүтэй байдлын дараагийн шалтгаан нь осол, гэмтэл, амиа хорлолт зэрэг **ГЭНЭТИЙН ХҮЧИН ЗҮЙЛС** байна.

## ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ



69%



31%

Бусад тээврийн осол-  
47% /хамгийн их/

Мотоциклийн осол

93%

7%

Явган зорчигч

61%

39%

Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бусад тээврийн ослоор **2.3** дахин их, мотоциклын ослоор **13.3** дахин, явган зорчигч **1.5** дахин их осолд орсон байна.

## АМИА ХОРЛОЛТ

58.5%

Амиа хорлох үедээ хүнд болон хөнгөн зэргийн соглолттой байсан.



85%



15%

**25-39** насныхан хамгийн их хувийг эзэлдэг.

Амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийг судалдаггүй, шалтгааныг тодруулах чиглэлээр ажиллахгүй байна.


1. 15-29 НАС: амиа хорлох, мотоциклтой осолд орох болон бусад тээврийн осол
2. 30-44 НАС: спиртэнд хордох, амиа хорлох
3. 45 + НАС: Халдварт бус өвчлөл, барилга байгууламжаас унах

# ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН НАС БАРАЛТЫН ШАЛТГААН

Насны бүлэг	I.Шалтгаан	II.Шалтгаан	III.Шалтгаан
<b>15-19 (1%)</b>	Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох-25 (20%)	Хий, ууранд санамсаргүй хордох, өртөх-13 (10%)	Мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх-9 (7%)
<b>20-24 (1%)</b>	Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох-36 (25%)	Мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх-14 (10%)	Бусад тээврийн осол-14 (10%)
<b>25-29 (2%)</b>	Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох-52 (23%)	Хүчирхийлэл, бусдад хорлогдох-19 (8%)	Бусад тээврийн осол-17 (7%)
<b>30-34 (4%)</b>	Спиртэнд санамсаргүй хордох, өртөх-60 (16%)	Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох-53 (14%)	Бусад тээврийн осол-18 (5%)
<b>35-39 (5%)</b>	Спиртэнд санамсаргүй хордох, өртөх-87 (17%)	Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал-47 боох (9%)	Элэгний фиброз ба цирроз-43 (8%)
<b>40-44 (6%)</b>	Спиртэнд санамсаргүй хордох, өртөх-105 (16%)	Тархины цус харвалт-47 (7%)	Зүрхний ишемит өвчин-37 (6%)
<b>45-49 (11%)</b>	Барилга байгууламжаас унах-158 (14%)	Аалзан хальсан (арахнойд) доорх цус харвалт-118 (11%)	Халдварт бус гастроэнтерит ба колит-84 (8%)
<b>50-54 (11%)</b>	Элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн-143 (13%)	Тархины цус харвалт-135 (12%)	Спиртэнд санамсаргүй хордох, өртөх-94 (8%)
<b>55-59 (12%)</b>	Элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн-217 (18%)	Тархины цус харвалт-142 (12%)	Зүрхний ишемит өвчин-127 (10%)
<b>60+ (40%)</b>	Зүрхний ишемит өвчин-654 (16%)	Элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн-499 (12%)	Бусад зүрх судасны тогтолцооны өвчин-456 (11%)

Эрэгтэйчүүд эмнэлгийн үзлэгт хамрагдалт бага байна.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ



ҮЗЛЭГТ  
ХАМРАГДСАН  
ШАЛТГААН



**1-3 дахин их-** Бусад өвчлөлөөр эмэгтэйчүүд их үзүүлсэн

**1.7 дахин их-** Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг




**1.1 дахин их-** Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг

- Амбулаторийн үзлэгт бүртгэгдсэн хүмүүсийн тооноос харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин бага.
- Эрэгтэйчүүдийн хувьд 20 наснаас эхлэн эрс буурч, эмнэлэгт үзүүлж буй эрэгтэйчүүд 32 хувь, эмэгтэйчүүд 68 хувьтай.
- Ялангуяа 25-34 насанд эрэгтэйчүүдийн үзлэгийн бүртгэл хамгийн бага.

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Эрэгтэйчүүдэд зориулсан эмнэлгийн үйлчилгээний **хүртээмж хангалтгүй** байна.



Зөвхөн улсын нэгдсэн төв эмнэлэгт урологи-андрологийн төв байдаг

1

ТӨВ

4

КАБИНЕТ

Бусад улсын эмнэлгүүдэд эрэгтэйчүүдийн тасаг сүүлийн жилээс нээгдэж эхлээд одоогоор нийт 4 буюу 3 аймаг, 1 дүүрэгт эрэгтэйчүүдийн кабинет ажиллаж байна.

!

ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ

Шаардлагатай үзлэгийн тоног төхөөрөмж хангалтгүй байдаг байна.

5

ХУВИЙН  
ЭМНЭЛЭГ

Улсын хэмжээнд эрэгтэйчүүдийн хувийн эмнэлэг 5 байдаг.

6

АНДРОЛОГИЧ

Улсын хэмжээнд байдаг учраас кабинет нээгдсэн ч ажиллах эмч мэргэжилтнүүд дутмаг.

# ХЭРЭГЖИЖ БУЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Монгол Улсын төрөөс дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр баримталж буй голлох 4 бодлого, нийгэм, эдийн засгийн нөлөөнөөс үүдэлтэй нас баралтыг бууруулах чиглэлээр тусган хэрэгжүүлж буй 9 хөтөлбөр байна.

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030

ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН  
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО  
2016-2025

ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО  
2017-2021

ТӨРӨӨС НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО  
2001




Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарын үндэсний хөтөлбөр 1997-2021



## ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА




### Байнга амьдарч байгаа газар




### Судалгаанд хамрагдсан 18-26 насны эрэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр

#### Төрсөн он



Эрүүл мэндийн урьчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байх хэрэгтэй гэж үзсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлгээр




Нийт эрэгтэйчүүдийн **89.8 хувь нь** эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт **хамрагдаж байх хэрэгтэй** гэж үзсэн бол 64.8 хувь (28.1 хувь нь 2019 онд 1 удаа, 29.7 хувь нь жилд тогтмол нэг удаа, 7.0 хувь нь улирал бүр) нь эрүүл мэндийн үзлэгт ямар нэг байдлаар хамрагдсан байна.



Эрэгтэйчүүд эмнэлэгт очих ер нь дургүй байдаг. Өвдсөн үедээ бүүр хүндэрсэн хойно нь л эмнэлэгт очдог, урьдчилан сэргийлэх зорилгоор бол огт үзүүлдэггүй.

*/Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн эмэгтэй бүлгийн ярилцлагаас/*

Эрүүл мэндийн урьчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байсан эсэх




**35.2 хувь нь буюу 3 эрэгтэй тутмын 1 нь** эрүүл мэндийн урьчилан сэргийлэх үзлэгт урьд өмнө огт хамрагдаж байгаагүй байна.

# Сүүлийн 12 сарын хугацаанд аав, төрсөн ах, эрэгтэй дүү нараас нас барсан тохиолдол бий эсэх

8.8  
ХУВЬ

## Нас барсан шалтгаан



	Тамхи сорж үзсэн эсэх	Анх тамхи татсан нас	Тамхи татдаг эсэх
18 - 20	66.5	15.9	43.9
21 - 23	67.2	17.0	47.2
24 - 26	63.4	17.5	45.0
Total	66.2	16.4	45.0




Анх тамхи  
татсан нас



Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 66.2 хувь нь дунджаар 16.4 насандаа тамхи сорж үзсэн бөгөөд 45.0 хувь нь одоо татдаг байна. Тамхи татдаг эрэгтэйчүүдээс сүүлийн 24 цагийн хэрэглээг тодруулахад 72.1 хувь нь 1-9 ширхэг тамхи, 15.4 хувь нь 10-20 ширхэг, 2.8 хувь нь 21 ширхэгээс их тамхи татсан бол 9.7 хувь нь сүүлийн 24 цагт тамхи татаагүй байна.

	Сүүлийн 24 цагийн тамхины хэрэглээ				
	Татаагүй	1-9 ширхэг	10-20 ширхэг	21-ээс олон	Total
18 - 20	11.1	72.9	13.6	2.4	100.0
21 - 23	7.9	70.6	18.0	3.5	100.0
24 - 26	8.3	71.6	17.5	2.6	100.0
Total	9.7	72.1	15.4	2.8	100.0

Нийслэлд амьдарч буй 2 эрэгтэйн нэг нь тамхи татаж байна.



	Согтууруулах ундаа хэрэглэж үзсэн	Анх согтууруулах ундаа уусан нас	Сүүлийн 1 сард согтууруулах ундаа хэрэглэсэн	Сүүлийн 1 сард согтууруулах ундаа хэрэглэсэн өдөр
18 - 20	48.4	17.4	32.9	4.2
21 - 23	64.3	18.8	42.4	3.7
24 - 26	65.3	19.4	43.4	3.7
Нийт	55.4	18.2	37.8	3.9

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 55.4 хувь нь дунджаар 18.2 насандаа согтууруулах ундаа хэрэглэж үзсэн байна. Сүүлийн нэг сард согтууруулах ундаа хэрэглэсэн эрэгтэйчүүд дунджаар 4 өдөр согтууруулах ундаа хэрэглэсэн байгаа нь эрэгтэйчүүд 7 хоног бүр согтууруулах ундаа хэрэглэж байгааг харуулж байна.

*Эрэгтэй хүүхдийг бага байхаас нь эрэгтэй хүн уйлж болдоггүй, эр хүн хатуужилтай байх хэрэгтэй гэх мэтээр сургадаг нь эрэгтэйчүүд сэтгэл хөдлөлөө гадагшлуулж чадахгүй стрессдэх, улмаар*

*архи, тамхи хэрэглэх,*

*урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлэгт үзүүлэхгүй байх,*

*өвдсөн үедээ эмнэлэгт очихгүй хүндрүүлэх зэрэг шалтгаан болж байгаа.*

*/Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн эмэгтэй бүлгийн ярилцлагаас/*



18

Анх согтууруулах ундаа уусан нас

4

удаа

Согтууруулах ундаа хэрэглэсэн өдөр



“Согтууруулах ундааг 5 хүн тутмын хоёр нь сүүлийн 1 сард хэрэглэсэн байна.”





Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс богино насалж байгаагийн шалтгаан




*Гар утсаар 96,7 хувь нь, интернэтээр 90,7 хувьд мэдээллийг хүргэх бололцоотой болсон.*

### Гар утасны хэрэглээ



### Интернет хэрэглээ



Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 96.7 хувь нь гар утас хэрэглэдэг ба 90.7 хувь нь интернет хэрэглэдэг бөгөөд 57.6 хувь нь байнга интернет хэрэглэдэг байна.

### Мэдээллийн эх үүсвэр

1. Интернет **73.1%**
2. Телевиз **24.4%**
3. Бусад **2.5%**

	Өртөж байгаагүй	Өртсөн		Нийт
		5 хүртэл удаа	5-аас дээш удаа	
Нийт	66.7	29.4	3.9	100.0
18 - 20	67.0	28.1	4.9	100.0
21 - 23	65.1	31.0	3.9	100.0
24 - 26	68.1	29.0	2.9	100.0

“3 хүн тутмын хоёр нь амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байгаагүй байна.”



Судалгаагаар эрэгтэйчүүдийн амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байсан эсэхийг тодруулсан бөгөөд нийт гурван эрэгтэй тутмын нэг нь ямар нэг байдлаар амь эрсдэхээр тохиолдолд өртөж байсан бөгөөд 4.4 хувь нь 5-аас дээш буюу олон удаа ийм байдалд орж байжээ

## Эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд




*Эрчүүд барилга дээр хар бор ажил их хийдэг. Гадаа даарч хөрөх нь их байдгаас дундаж наслалт нь бага байхад нөлөөлдөг байх. Халуунд тоосгоны үйлдэрт ажилсан хүний шүд нь хар залуугаараа бүгд унаад өгдөг. Тээврийн жолооч нарын хувьд олон цагаар нойргүй явдаг тамхи ихээр татдаг, буруу хоололт ихтэй*

*/Дундговь аймгийн эрэгтэй бүлгийн ярилцлагаас/*

	Бага байхдаа ажил хийж байсан	Бага байхдаа хүнд ажил хийж байсан	Бага байхдаа хүнд ажил эрхэлж байсан шалтгаан			Нийт
			Гэрийн ажилд туслах	Мөнгө олох	Бусад	
<b>Нийт</b>	<b>45.6</b>	<b>56.1</b>	<b>36.7</b>	<b>57.3</b>	<b>6.0</b>	<b>100.0</b>
18 - 20	43.8	49.5	33.7	58.4	7.9	100.0
21 - 23	48.1	58.5	35.1	58.9	6.0	100.0
24 - 26	45.0	60.4	41.2	54.5	4.3	100.0

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 45.2 хувь нь бага байхдаа ажил хийж байсан бөгөөд тэдний тал (53.8 хувь) нь хүнд ажил хийж байсан байна. Хүнд ажил хийж байсан эрэгтэйчүүдийн 57.9 хувь нь мөнгө олох, 35.4 хувь нь гэрийн ажилд туслах, үлдсэн 6.7 хувь нь бусад зорилгоор бага байхдаа хүнд ажил эрхэлдэг байсан байна.

Эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эрхэлдэг хөдөлмөр нь эрсдэлтэй эсэх, насны бүлэг, хувиар





# ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Чанарын судалгааны хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд 18-29 насны эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлага хийж эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү, эрэгтэйчүүдийн дундаж наслалтад нөлөөлж буй зан үйл, тухайн орон нутгийн дундаж наслалтын талаар, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх боломжийн талаар судалсан.



Харин ярилцлагад оролцогчид эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо сэтгэлзүй, физиологи, хорт зуршлын хэрэглээ, ёс суртахуун, шашин шүтлэг, эмнэлэгт үзүүлэх хандлагаараа ялгаатай гэж бодож байсан. Жишээ нь:

- Эрэгтэйчүүд эмэгтэй хүнээс бие физиологийн хувьд өөр – **Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хүч чадалтай**, тийм учраас хар ажил, уул уурхай барилга дээр ихээр ажилладаг.
- Эрчүүд эмэгтэйчүүдээс сэтгэл зүйн хувьд муу. **Стрессээ гадагшлуулдаггүй**, иймд стрессээ гадагшлуулах, **сэтгэлээ тайвшруулахын тулд тамхи татах, согтууруулах ундаа** хэрэглэх гэх мэт **буруу зуршлуудыг** сонгодог.
- Ёс суртахууны хувьд эрэгтэйчүүд их нэрэлхүү байдаг. **Эр хүн хүчирхэг байх ёстой, эр хүн өвддөггүй** гэх мэт буруу үзлээс болоод эрэгтэйчүүд **эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, эмнэлэгт** эмчлүүлэх зэрэгтээ муу байна.

Ярилцлаганд оролцогчдын дийлэнх нь дундаж наслалт, эрүүл мэндийн судалгааны талаар сайн мэдэхгүй байсан бөгөөд дундаж наслалтын тооцоог хийхдээ ямар үзүүлэлтүүдээс хамааруулж тооцдогийг мэдэхгүй учраас юу нөлөөлж байгааг сайн мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

# САНАЛ, ЗӨВЛӨМЖ


Эрүүл мэнд

## БОДЛОГЫН ТҮВШИНД

Монгол улсын хэмжээнд дундаж наслалтын зөрүүг багасгах, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх замаар дундаж наслалтыг **шууд болон шууд бусаар** нэмэгдүүлэхэд чиглэсэн **богино болон дунд** хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах, тэдгээр бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг **тодорхой ОНОВЧТОЙ** болгох, эдгээр нь **ХЭМЖИГДЭХ** боломжтой байх

Нийгмийн хамгаалал


Боловсрол



- Мэдээлэл, сурталчилгааны агуулгад тодорхой шалгуур тавих
- Стандартыг мөрдүүлэх

Соёл, урлаг

Биеийн тамир, спорт



Судалгаагаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг чухал гэж гарсан боловч эрэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт муу байна. Иймд эрэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад чиглэсэн шат дараалласан арга хэмжээ авах;

1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх;
2. Бүлэг бүрт чиглэсэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг явуулах, - Сургууль, цэрэг, ажиллагчид гэх мэт;
3. Малчдад зориулсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх явуулын үзлэг, оношилгоог бий болгож, тогмолжуулах;
4. Эрэгтэйчүүдийн эмч бэлтгэх асуудлыг бодлогоор дэмжих, эрүүл мэндийн төвүүдэд эрэгтэйчүүдийн үзлэгийн өрөө бий болгох, одоо ажиллаж байгаа эмч, эмнэлэгийн ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх;
5. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын ажиллагчдын жендэрийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлж, хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх мэдээлэл, мэдлэгийг олгох сургалтыг орон даяар нэгдсэн журмаар явуулах хэрэгтэй.




## Нийгмийн хамгаалал

Захиргааны мэдээллээс харахад осол гэмтэлд орсон нийт иргэдийн 62.2 хувь нь эрэгтэй байна. Иймд авто осол, хүнд хөдөлмөр эрхлэлтээс болж эрсдэж байгаа байдлыг бууруулах чиглэлээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах асуудалд анхаарах хэрэгтэй байна.

- Уул уурхай, барилга авто тээврийн салбарын дийлэнх ажиллагч нь эрэгтэйчүүд байдаг бөгөөд эдгээр салбарт үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл өндөр байдаг. Иймд эдгээр салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайн сахих чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах;
- Үйлдвэрлэлийн осол өртөгч, мэргэжлээс шалтгаалсан өвчинтэй иргэдийг нөхөн сэргээх, амарч сувилуулахад нийгмийн даатгал, нийгмийн халамжаас үзүүлэх дэмжлэгийг сайжруулах;
- Бүх нийтээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахад нийгмийн даатгал, халамжаар дамжуулан үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх;


Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрэгтэй хүүхдүүдийг сургууль, гэр бүлийн орчинд эрүүл мэнддээ анхаарах тусгайлсан хөдөлбөр, хичээл явуулах.

## Боловсрол



- Бага боловсролоос эхлэн муу зуршлын хор нөлөөг сайн таниулах,
- Зөв хооллолт, амьдралын зөв хэв маягийн талаар таниулах хичээл суулгах;
- Үлгэрлэн таниулах аргыг одоогийн аав, ээжүүдэд ухуулан таниулах
- Эрэгтэй хүүхдийг стрессээ гадагшлуулах, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг болгоход анхаарах;
- Сургуулиудад сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ажиллуулах;





Залуучууд дасгал хөдөлгөөн хийх нь эрүүл мэндэд чухал гэж үзсэн боловч гуравны нэг нь буюу 30.3 хувь нь тогтмол дасгал хөдөлгөөн хийдэг бол 53.9 хувь нь хааяа дасгал хөдөлгөөн хийдэг, үлдсэн 14.2 хувь нь огт дасгал хөдөлгөөн хийдэггүй байна. Иймд бүх нийтийн эрүүл мэнд, бүх нийтийн биеийн тамирыг олон нийтэд сурталчилах.

- Дасгал хөдөлгөөн хийснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, урт удаан амьдрах боломжтойг сурталчилах;
- Залуучуудын чөлөөт цагаа зөв, боловсон өнгөрүүлэх боломжтой газруудыг нэмэгдүүлэх;

### Соёл урлагийн чиглэлээр

Нийгэмд тогтсон буруу хандлагыг засаж залруулах, зөв зан үйлийг сурталчилсан контент бэлтгэх; Телевизийн олон ангит кино; Залуучуудын ихээр сонирхож буй урлагийн урсгалын төлөөлөлтэй хамтран ажиллах;

### Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр

Мэдээлэл харилцаа гар утас, интернетийн хэрэглээг зөв ашиглах хэрэгтэй. Эдгээр сувгуудаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг сайжруулах кампанит ажил өрнүүлэх, мэдээлэл тэгээх хэрэгтэй.

